

## 4

### **БОЛОВСРОЛЫН САЛБАРТ МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙГ НЭВТРҮҮЛЭХ БОДЛОГО, СТРАТЕГИЙН ХЭРЭГЖИЛТЭНД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

**Д.Чимгээ. Ц.Ганбат. Ю.Алтантуяа**

#### **Нийтлэг үндэслэл**

Боловсролын салбарт МХХТ нэвтэрснээр дэлхийн улс орнуудын боловсролын тогтолцоонд ихээхэн өөрчлөлтүүд гарч сургалтын шинэ тогтолцоо бүрэлдэж байна. Үүнтэй уялдан сургуулиудын хэв шинж, багшийн үүрэг ч ихээхэн өөрчлөгдөж байна. Багш төвтэй сургалтаас сурагчдын бие даан суралцах болон идэвх, чармайлтыг нь өрнүүлэх, бүтээлчээр сэтгэх, шинийг санаачлах үйл ажиллагааг нь дэмжсэн шавь/оюутан/ төвтэй, цаашилбал мэдлэгд суурилсан сургалт руу шилжиж байна. Боловсролд гарч буй эдгээр өөрчлөлтүүд нь тэр бүр аятай таатай байдаггүй, нэвтрүүлэх явцад технологи эерэг, сөрөг талтай байдаг болохыг харуулсан жишээ мөн гарч байна.

Боловсролын салбарыг хөгжүүлэхэд мэдээллийн технологийн гүйцэтгэх үүрэг, түүний үр нөлөөг нэмэгдүүлэх явдал бидний тулгамдсан асуудлын нэг болов. Монгол улсын Засгийн газар Боловсролын бүх түвшинд багшлах, суралцах үйл ажиллагаанд МХХТ-ийг нэвтрүүлэх нь сургалтын чанарыг сайжруулах нэг үндсэн арга гэж үзэж үүнийг бодлогын баримт бичгүүд, хөтөлбөрт тусгасан.

Сургалтын үр өгөөж, чанарыг дээшлүүлэх үндсэн нөхцөл нь сургалтыг бие даалгах хэлбэрээр явуулах явдал юм. МХХТ-ийг сургалтанд үр бүтээлтэй

ашигласнаар суралцагчид хэнээс ч хамаарахгүй бие даан суралцах боломжоор хангагдаж байгаа нь туршлагаас тодорхой болжээ. Монгол улсын боловсролын шинэчлэлийн хүрээнд хийгдэж буй ажил нь боловсролын тогтолцоог бүтэц, бүрэлдэхүүн, агуулга, арга зүй, технологийн талаас шинэчлэн боловсронгуй болгоход чиглэгдэж байна.

Улс орны дэвшүүлсэн бодлогын болон стратегийн асуудлуудын үр дүн болон хэрэгжилтийн ахиц, өөрчлөлтийг хянах, шинжлэх болон үнэлэх зорилгоор индикаторууд нь тодорхойлогддог. Иймээс Монгол улсын боловсролын бүх шатны байгууллага, эрдэмтэн судлаач, мэдээллийг боловсруулагч, хэрэглэгчдэд МХХТ-ийн хэрэглээний индикаторууд болон энэ чиглэлээр статистикийн үзүүлэлт, тэдгээрийн ойлголт, тодорхойлолтын талаар цэгцтэй ойлголт өгч тодорхой нэгдсэн арга зүйгээр хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү судалгааны ажлыг хийлээ. Энэ ажлын хүрээнд боловсролын салбарт 2006-2015 онуудад МХХТ-ийг нэвтрүүлэх бодлого, стратегийн хэрэгжилтийн байдалд хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөхдөө баримтлах энэхүү шалгуур үзүүлэлтүүд, тэдгээрийг олон улсын боловсролын байгууллага болон бусад гадаад орнуудынхтай харьцуулан авч үзсэн болно.

Түлхүүр үг: Боловсролын салбарт МХХТ-ийн нэвтрүүлэх үйл ажиллагааны индикатор, Сургуулийн МХХТ-ийн хэрэглээний индикатор, Сургалтан дахь МХХТ-ийн хэрэглээ буюу интеграцчилал, тоон болон чанарын индикатор

### **Судалгааны хүрээ:**

Шалгуур үзүүлэлтүүд буюу МХХТ-ийн хэрэглээний индикаторуудын хамрах хүрээнд дараахи үйл ажиллагааг багтаасан болно. Үүнд:

2. Боловсрол Соёл Шинжлэх Ухааны яам, үйл ажиллагаа
3. Яамны харьяа газрууд, үйл ажиллагаа;
4. Орон нутгийн удирдлага, Боловсрол, соёлын газрууд, үйл ажиллагаа;
5. Дээд боловсролын байгууллагууд, үйл ажиллагаа;
6. Мэргэжлийн боловсролын байгууллагууд, үйл ажиллагаа;
7. Бага дунд боловсролын байгууллагууд, үйл ажиллагаа;
8. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд, үйл ажиллагаа;
9. МХХТ-ийн салбарын болон худалдан авалтын үйл ажиллагаа;
10. МХХТ-ийн салбарын үйл ажиллагаа зэрэг болно.

Дээрх үйл ажиллагааны хүрээнд боловсролын салбарын МХХТ-ийн нэвтрүүлэлтийн болон хэрэглээний индикаторуудыг дараах байдлаар ангилан авч үзлээ. Үүнд:

3. Боловсролын салбарт МХХТ-ийг нэвтрүүлсэн үйл ажиллагааны гол үзүүлэлтүүд
4. Сургуулийн МХХТ-ийн хэрэглээний гол үзүүлэлтүүд,
5. Сургалтан дахь МХХТ-ийн хэрэглээний гол үзүүлэлтүүд

Эдгээр үзүүлэлтүүдийг боловсролын салбарын үндсэн үйл ажиллагаатай холбон авч үзсэн.

### **МХХТ-ийн хэрэглээний ялгаатай түвшинг илтгэх индикаторууд**

Судалгаанаас үзэхэд МХХТ-ийн хэрэглээний индикаторуудыг дотор нь 3 хувааж үздэг байна: оролтын, явцын, гаралтын индикаторууд. Үүнд:

1. **Оролтын индикаторууд (Input indicators):** компьютер ба сурагчийн тооны харьцаа, Интернетийн холболт ба хурд, боловсролын зориулалттай програм хангамж ба бэлэн сургалтын програм хэрэгслүүд зэрэг үзүүлэлтүүд багтдаг.
2. **Хэрэгжүүлэлтийн индикаторууд (Utilization indicators):** мультимедиа програм хэрэглэдэг хичээлүүд, интернет болон компьютерийн лаборатори ашигладаг хичээлийн эзлэх хувь, сургалтын цахим хэрэглэгдэхүүн, цахим контент ашиглаж хичээл заадаг багшийн эзлэх хувь, сурагчдын компьютерийн хэрэглээ болон интернетийн хэрэглээ зэрэг үзүүлэлт орно. МТ-ийн хичээл судалдаг сурагчдын тоо
3. **Гаралтын индикаторууд (Output indicators):** э-шуудангийн хаягтай багш болон сурагчийн тоо, вэб сайттай сургуулийн тоо, МХХТ-ийн мэргэжлийн сертификаттай багшийн тоо, МХХТ-ийн 32 цагийн сургалтыг дүүргэсэн сурагчдын тоо, г.м.

МХХТ-ийн хэрэглээний индикаторуудыг авч үзье.

### **Нэг. Монголын зарим байгууллагаас гаргасан индикаторууд**

Өнөөгийн байдлаар Үндэсний Статистикийн Хорооноос Монгол улсад МХХТ-ийн салбарын хөгжлийн бодлого стратегид чиглэгдсэн 4 багц асуудлаар олон улсын байгууллагуудын зөвлөмж, туршлагаас судалж МХХТ-ийн салбарын үйл ажиллагааны индикаторуудыг багтаасан “Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг боловсруулсан (2010 оны 12 сард) бөгөөд өнөөдөр улсын хэмжээнд мөрдөж эхлээд байна.

Үндэсний Статистикийн Хорооноос баталж гаргасан статистикийн эдгээр шинэхэн үзүүлэлтийн нэг нь боловсролын салбарын МХХТ-ийн хэрэглээний дараахи 9 гол үзүүлэлтүүдийг (Хүснэгт 1) нийтээр хэрэглэхээр заасан байна.

Хүснэгт 1

№	Үзүүлэлт
ICT4E-IND01	ЕБС-д ашиглаж буй радиотой сургуулийн эзлэх хувийг
ICT4E-IND02	ЕБС-д ашиглаж буй телевизортой сургуулийн эзлэх хувийг
ICT4E-IND03	Суурин утастай сургуулийн эзлэх хувийг
ICT4E-IND04	Нэг компьютерт ногдох сурагчдын эзлэх хувийг
ICT4E-IND05	Интернэтийн холболттой сургуулийн эзлэх хувийг холболтын төрлөөр Нарийн зурвасын интернэтийн холболттой сургуулийн эзлэх хувийг Өргөн зурвасын суурин интернэтийн холболттой сургуулийн эзлэх хувийг Нарийн болон өргөн зурвасын интернэтийн холболттой сургуулийн эзлэх хувийг
ICT4E-IND06	ЕБС-ийн интернэтээр үйлчлүүлдэг сурагчдын эзлэх хувийг
ICT4E-IND07	МХХТ-ийн чиглэлээр их, дээд сургууль, коллежид суралцаж буй суралцагчдын эзлэх хувийг хүйсээр
ICT4E-IND08	ЕБС-ийн МХХТ-ийн мэргэжилтэй багшийн эзлэх хувийг
ICT4E-IND09	Цахилгааны хангамжтай сургуулийн эзлэх хувийг

Мөн түүнчлэн БСШУЯ-наас “Бага, дунд боловсролын салбарт 2015 он хүртлэх хугацаанд мэдээллийн технологийг нэвтрүүлэх үндсэн чиглэл” (БСШУЯ-ны 2006 оны 405 тоот тушаал) –ийн хэрэгжилтэнд хяналт, шинжилгээ хийх шалгуур үзүүлэлт, аргачлалыг бүх шатны сургуулиудын хувьд авч хэрэглэхээр заасан байна. Эдгээр 12 үзүүлэлтийг хүснэгт 2-д үзүүлэв.

Хүснэгт 2

№	Үзүүлэлт
ICT4E-IND10	Бага дунд боловсролын удирдлагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдсон сургуулийн эзлэх хувь
ICT4E-IND11	Цахим хэлбэрт шилжүүлсэн хичээлийн хөтөлбөрийн эзлэх хувь.
ICT4E-IND12	Цахим номын сан байгуулах явц
ICT4E-IND13	Сурагч компьютерийн харьцааны нэгдсэн индекс
ICT4E-IND14	Компьютер түүний дагалдах хэрэгслээр тоноглогдсон кабинеттай сургуулийн хувь
ICT4E-IND15	Сургуульд ашиглаж буй өндөр хурдтай процессор бүхий компьютерийн хувь
ICT4E-IND16	Сургалтанд нотебүүк компьютер ашигладаг багшийн хувь
ICT4E-IND17	Вэб хуудастай ЕБС-ийн хувь
ICT4E-IND18	Мэдээлэл зүйн багшийн хангалтын хувь
ICT4E-IND19	Ээлжит хичээлдээ компьютер ашигладаг багшийн хувь
ICT4E-IND20	Мэдээллийн технологийг сургалтанд нэвтрүүлэх чиглэлээр явуулж буй сургалтанд зарцуулсан зардлын хувь
ICT4E-IND21	Сургуулийн удирдах Ажилдаа компьютер ашигладаг сургуулийн удирдах ажилтны хувь

БСШУЯ-наас дээрхи хөтөлбөрийн хэрэгжилтэнд мониторинг хийх индикаторуудаас гадна дараах үзүүлэлтүүдийг нэмэлт байдлаар жил бүр тооцож гаргадаг байна.

№	Үзүүлэлт
ICT4E-IND22	Мэдээлэл зүйн кабинетийн тоо:
ICT4E-IND23	Интернэтэд холбогдсон компьютерийн тоо:
ICT4E-IND24	Компьютерийн хүчин чадлын үзүүлэлт, тоо: Захиргаанд, Сургалтанд, Пентиум III ба түүнээс дээш
ICT4E-IND25	Компьютерийн дагалдах төхөөрөмжийн тоо: принтер, сканнер, проектор

Иймд 2011 оноос боловсролын салбарын хувьд нийт 25 индикатор үзүүлэлтийг тооцож боловсролын салбар дахь МХХТ-ийн нэвтрүүлэлт болон хэрэглээний асуудлаар дэвшүүлсэн зорилго зорилтууд хэрхэн биелж байгааг үнэлж, цаашдын стратегийн болон хэрэгжүүлэх төлөвлөгөөг сайжруулахад хэрэглэх юм.

**Гурав. МХХТ-ийг боловсролд амжилттай нэвтрүүлсэн гадаадын улс орнуудын индикатор үзүүлэлтүүдийг судалсан нь**

Гадаад улс орнуудын МХХТ-ийн хэрэглээний индикаторуудыг Англи, Америк зэрэг орнуудын жишээн дээр судалж үзээд нэгтгэсэн дүгнэлтийг хүснэгт 3-д үзүүлээ.

### 3. Олон улсын жишээ, харьцуулалт

<b>Технологийн хэрэглээний стандартууд</b>	МХХТ-ийг хэрэглэснээр багш болон сурагчийн мэдлэг, ур чадвар болон хандлагад ямар өөрчлөлт гарах вэ? гэсэн дунд хугацааны үр дүнг харьцуулах зорилгоор технологийн хэрэглээний цөөн стандартыг тодорхойлно
<b>МХХТ-ийг сургалтанд хэрэглэх түвшин</b>	Дийлэнхи улс оронд бага, дунд боловсролд МХХТ-ийг сургалтанд хэрхэн хэрэглэж байгаа тухай судалдаг. Гэхдээ Солонгост дээд боловсролыг, Словенид сургуулийн өмнөх боловсролыг нэмж оруулдаг бол, АНУ-д бага, дунд ангийн биеийн тамир болон зарим хичээлээр МХХТ-ийг хэрэглэхгүй байх тухай заасан байдаг бол Японд МХХТ-ийг тусгай сургуулиудад (хараагүй болон хөгжлийн бэрхшээлтэй), Австралид албан бус боловсролыг оруулж судалдаг байна.
<b>МХХТ-ийн дэд бүтэц, техник хангамж ба холболт</b>	Сургуулиудын компьютерийн тоо болон интернетэд холбогдсон холболтын талаархи статистик авдаг. Австрали, Энэтхэг, Шинэ Зеланд, Солонгос, Тайланд ба Филиппин утасны шугам, факс, ЛСД прожектор гэх мэт өөр төрлийн технологийн талаар нэмж оруулсан байдаг. <b>Мэдээллийн технологи:</b> Мэдээллийг электрон байдлаар илэрхийлж оруулах, хадгалах, боловсруулах, зориулалт бүхий техник хэрэгслүүд болон програм хангамж юм. Персонал компьютер, сканнер, тоон зургийн аппарат зэрэг нь техник хангамжид орно. <b>Харилцаа холбооны технологи:</b> Мэдээлэл дамжуулах, хандах зориулалт бүхий утас, факс, модем болон сүлжээний тоног төхөөрөмжүүд ордог. <b>Мэдээллийн технологийн бичиг үсэг тайлагдалт:</b> Мэдээллийн эрин

	зуунд амьдарч байгаа иргэн бүрийн мэдлэг, ойлголт, ур чадвар ба зан төлөвийн хандлагын нийлмэл үр дүн тодорхойлдог. Хэрэв сурагчийн мэдээллийн технологийн бичиг үсгийн боловсрол өндөр бол тэд мэдээлэл сонгох, ойлгох, хөгжүүлэх, хувиргах мэдлэг чадвартай байна.
<b>Багшийн МХХТ-ийн хэрэглээ</b>	Багш нар хичээл заахдаа МХХТ-ийг хэрхэн хэрэглэж зааж байгааг судалдаг. Ихэнхи тохиолдолд тодорхой ямар хичээлүүдийг заахад хэрэглэж байгааг, интернетийн боломжийг хэрхэн хэрэглэж байгааг, бусад багш нар болон сурагчидтай харилцаж холбогдоход э-шууданг хир өгөөжтэй хэрэглэж байгааг, мөн өөрийн вэб сайтыг хөгжүүлж байгаа зэргийг судалдаг. Австралид багшийн СД дээр бичигдсэн хичээлийн материалыг бүртгэдэг бол зарим улс оронд багшийн компьютерийн боловсрол, ур чадвар ямар болохыг судалдаг, жишээ нь Филиппин. Солонгос блон Австралид багш бүрийг компьютерээр хангасан байна.
<b>Судалгааны чанарын индикаторууд</b>	Сурагч ямар ахиц өөрчлөлт гарсан гэж үзэж байгааг судалдаг. Жишээлбэл, - багшийн заах аргад гарсан өөрчлөлт - МХХТ-ийн хүсэж мөрөөдөж буй ур чадварууд - Харилцаа холбооны хэрэгслийн хэрэглээг сайжруулах хүчин зүйлүүд - Сургууль дээрхи технологитой холбоотой аливаа үйл ажиллагаанд нааштай эерэг ханддаг сурагчийн эзлэх хувь, - МХХТ-ийн хэрэглээ нь сургах болон сурах үйл ажиллагааг дэмждэг гэдэгтэй санал нийлдэг багшийн эзлэх хувь - Багш, сурагчид өөрсдийгөө төрөл бүрийн төсөл, даалгавар хийх ур чадвар нь сайжирсан гэж үздэг үү - Багшийн МХХТ-ийн хэрэглээнд сурч итгэлтэй, тав тухтай байж чаддаг уу - Практикийн, үндсэн болон дадал зуршил болж хөгжиж байгаа байдал - Багш нар болон сурагчдад компьютерийн үзүүлж буй нөлөөлөл - Компьютертэй холбоотой саад бэрхшээлүүд

**Улс орнуудад хийгдсэн зарим судалгаа:**

1. **Англи улс:** 2001 онд сургуулиудаас авсан МХХТ-ийн судалгааг дараахи чиглэлүүдээр авч, 1998 онд авсан судалгааны дүнтэй харьцуулж өсөлт, өөрчлөлтөд дүгнэлт хийсэн байна. Үүнд:  
 Бүх шатны сургууль бүрээр компьютерийн тоо, хүчин чадлын үзүүлэлт төрөл ангиллаар  
 Интернетийн хэрэглээ болон интернетийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд, тэдгээрээс үзүүлдэг үйлчилгээний талаар  
 Багшийн сургах үйл ажиллагаан дахь МХХТ-ийн хэрэглээ болон багш нарын МХХТ-д хандах хандлага  
 МХХТ-ийн нэвтрүүлэлт зарцуулсан хөрөнгө оруулалт болон ашиглалтын зардал, сургууль бүрээр
2. **Харвардын Их Сургууль:** Сүлжээний бэлэн байдлын индекс (Network Readiness Index) гаргах судалгааг олон улсын байгууллагуудтай хамтран 2001 онд явуулж, дэлхийн 75 улс орныг хамарсан бэлэн байдлын

жагсаалтыг гаргасан. Жагсаалтыг АНУ тэргүүлж, араас нь Ирланд, Финланд, Швед, Норвег, Голланд, Герман, Сингапур, Австри, Англи улсууд эхний 10-т багтсан бол Азийн улс орнуудаас Солонгос 20, Япон 21, Малайз 26, Тайланд 43, Энэтхэг 54, Филиппин 58, Индонез 59, Шриланк 62, Хятад 64, Бангладеш 73, Вьетнам 74-т орсон байна.

Судалгааг сүлжээний хэрэглээ болон хүчин зүйлүүд гэсэн 2 багц асуудлаар авчээ. Интернет хэрэглээ гэдэгт 100 хүнд ноогдох интернет хэрэглэгчийн тоо, 100 хүнд ноогдох гар утасны хэрэглэгчийн тоо, 1 хостод ноогдох интернет хэрэглэгчийн тоо, интернетэд холбогдсон компьютерийн тоо хувиар, интернетэд хандах төр олон нийтийн чадвар боломжит байдал (Internet users per hundred inhabitants, cellular subscribers per hundred inhabitants, internet users per host, percentage of computers connected to the internet and availability of public access to the internet)

Хүчин зүйлүүдэд: сүлжээний хандалт, сүлжээний бодлогын асуудлууд, сүлжээнд суурилсан нийгэм болон эдийн засаг гэсэн 4 асуудлыг багтаасан байна. Сүлжээний хандалтад мэдээллийн дэд бүтэц, компьютерийн техник хангамж, програм хангамж болон бусад туслах хэрэгслүүдийг авч үзэж, харин сүлжээний бодлогод мэдээлэл болон харилцаа холбооны бодлогын орчин, бизнесийн болон эдийн засгийн байдлыг судалж үзсэн байна. Сүлжээний нийгэм гэдэгт МХХТ-ийг сурах үйл ажиллагааны чанарыг сайжруулах болон хүрээг тэлэхэд хэрхэн хэрэглэж байгааг, харин сүлжээний эдийн засаг гэдэг ойлголтонд төр, хувийн хэвшлийн салбар дахь өөрчлөлт, ялангуяа э-засаглалыг нэг дэд асуулт болгож дүгнэсэн байна.

3. **Сингапур улс:** Боловсролын яамны санхүүжилтээр хийгдэх судалгааны эхний 1-р шатны судалгаанд: 168 бага сургууль, 144 дунд сургууль болон 16 коллеж буюу нийт 328 сургуулийг хамруулсан байна. Судалгааны үр дүнг товч томъёолбол,

МХХТ-ийн хэрэглээ, нөхцөл боломж болон соёлын түвшин нь улс орны хэмжээнд гаргасан МХХТ-ийн мастер төлөвлөгөөний 1-р зэрэглэлд багтсан сургуулиудын багш болон сурагчийн хувьд 3-р зэрэглэлийнхээ харьцангуй өндөр байв.

Биеэ даасан автономит сургуулиудын хувьд МХХТ-ийн олон төрлийн нөөцийн удирдлага менежмент нь, багш сурагчдын МХХТ-ийн хэрэглээ болон боломж, соёлын түвшин нь улсын сургуулийнхыг бодвол илүү сайн болох нь харагдсан байна.

Бага болон дунд сургууль, коллежийн хувьд МХХТ-ийн нөөцийн болон багш сурагчдын МХХТ-ийн хэрэглээ, ажилтнуудын хөгжил болон МХХТ-ийн хэрэглээний соёлын удирдлага, менежментийн асуудалд зарчмын ялгаа байдаггүй.

6. МХХТ-ийн нөөцийн болон багш, сурагчдын МХХТ-ийн хэрэглээ, ажилтнуудын хөгжил болон МХХТ-ийн хэрэглээний соёлын асуудлууд нь тэдгээрийн удирдлага, менежментийн асуудлуудтай шууд эерэг хамааралтай болохыг анализ шинжилгээний дүн харуулжээ.

### Энэхүү судалгаанаас гарсан дүгнэлт

Энэхүү судалгаанаас дараахи дүгнэлтийг гаргав. Үүнд:



Монгол улсын засгийн газраас боловсролын салбарт МХХТ-ийг нэвтрүүлэхэд ихээхэн анхаарал хандуулж байна. Үүний нэг илрэл нь Бага, дунд боловсролын салбарт 2015 он хүртлэх хугацаанд МХХТ-ийн нэвтрэлтэнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтүүд болон тэдгээрийн аргачлалыг батлан гаргасан байна.



Төр засгийн зүгээс МХХТ-ийг улс орны тэргүүлэх чиглэлийн нэг хэмээн үзэж ҮСХ-ноос Боловсролын салбарын МХХТ-ийн гол статистик үзүүлэлтүүдийг шинээр хэрэглэхээр оруулсан нь МХХТ-ийн тусламжтай боловсролын салбарын чанар, хүртээмж, үр ашгийг дээшлүүлэхэд анхаарч байгааг харуулж байна.



Хэдийгээр зарим нааштай ахиц харагдаж байгаа ч МХХТ-ийн хэрэглээний индикаторууд нь ангилал байхгүй, голдуу дэд бүтцийн талаарх индикаторууд орсон байна. Гэтэл МХХТ-ийн нэвтрүүлэлтийн хэмжээ, ашиглалтын байдал, үр ашиг, хэрэглэгчдийн сэтгэл ханамж, улсын хэмжээний үр өгөөж зэрэг чухал чиглэлүүдээр индикаторууд хангалтгүй байна.



Одоогийн байдлаар боловсролын салбарт МХХТ-ийг нэвтрүүлэх бодлого, стратеги одоогоор байхгүй, боловсруулалтын шатандаа явагдаж байна. Иймээс боловсролын салбарт МХХТ-ийг нэвтрүүлэх чиглэлээр үйл ажиллагааны хэрэгжилтийг хянах, үнэлэх цогц шалгуур үзүүлэлтийн систем гараагүй байна.



МХХТ-ийн хэрэглээний шалгуур болон статистик үзүүлэлтүүд нь түүний хэрэглээг боловсролын байгууллагын үйл ажиллагааны хүрээнд цогц байдлаар үзүүлж чадахгүй байна.



БСШУЯ-наас жил бүр тооцож гаргадаг үзүүлэлтүүд нь ихэвчлэн дэд бүтцийн чиглэлээр байгаа нь үйл ажиллагааг цогцоор авч үзэж, дүн шинжилгээ хийхэд хангалттай мэдээлэл болж чадахгүй байна.



Боловсролын салбарт МХХТ-ийг нэвтрүүлэхтэй холбоотой чанарын шалгуур үзүүлэлтүүд хангалтгүй, энэ чиглэлээр дорвитой судалгаанууд хийгдэхгүй байна.

### Судалгаанаас гарсан зөвлөмж



Индикаторууд нь улс орны дэвшүүлсэн бодлогын болон стратегийн асуудлуудын зорилгоор тодорхойлогддог.



Боловсролын салбарт МХХТ-ийг нэвтрүүлэх бодлого, стратегийн үр дүн болон хэрэгжилтийн ахиц, өөрчлөлтийг хянах, шинжлэх болон



үнэлэх хэрэгжилтийг хянах, үнэлэх цогц шалгуур үзүүлэлтийг боловсруулан гаргах



Дээр дурдсан шалгуур үзүүлэлтүүдийг гаргахдаа гадаадын орнуудын сайн туршлагыг харгалзан үзэх



Шалгуур үзүүлэлтүүдэд шаардлагатай мэдээллийг нэмэлтээр авч баяжуулах



Боловсролын салбарт МХХТ-ийн ахиц дэвшлийг харуулах чанарын үзүүлэлтэд анхаарах, шаардлагатай судалгаануудыг тогтвортой байнга хийх шаардлагатай байна.

### **Ном зүй.**

- 3 Боловсролын салбарт МХХТ-ийг 2015 он хүртэл нэвтрүүлэх бодлого стратегийн төсөл, “Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал” (ҮСХ-ны даргын 2010 оны 1/175 тоот тушаал),
- 4 “Бага, дунд боловсролын салбарт 2015 он хүртлэх хугацаанд мэдээллийн технологийг нэвтрүүлэх үндсэн чиглэл” (БСШУЯ-ны 2006 оны 405 тоот тушаал)
- 5 Нэгдсэн Үндэстний Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын байгууллага (UNESCO)-ын “Боловсролд МХХТ-ийн хэрэглээний индикатор үзүүлэлтийг хэрэглэх ба хөгжүүлэх нь”
- 6 "Цахим Монгол" хөтөлбөр